

**"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК-ИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХОРООНЫ ХУРЛЫН ШИЙДВЭР**

2024.07.04

№01

Улаанбаатар хот

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн Эрсдэлийн удирдлагын хорооны 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хурлаар

ХЭЛЭЛЦСЭН НЬ: "Монголын төмөр зам" ТӨХК-ийн "2024 оны Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэж, цаашид компанийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлүүдийг тодорхойлох.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. "Монголын төмөр зам" ТӨХК-ийн 2024 оны Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 13 арга хэмжээ тусгаж Гүйцэтгэх захиралд танилцуулахаар шийдвэрлэв.

2. Эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд төсөв хөрөнгө шаардлагатай 7 арга хэмжээний жагсаалтыг гаргаж 2024 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшний тодотголд тусгах, үлдсэн арга хэмжээнүүдийг 2025 оны төсөвт оруулах бэлтгэл ажлыг хийхээр шийдвэрлэв.

"Монголын төмөр зам" ТӨХК-ийн 2024 оны эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд орсон арга хэмжээний хэрэгжилт болон гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Эрсдэлийн удирдлагын хорооны дарга /М.Эрдэнэсайхан/, тайланг нэгтгэж ажиллахыг Эрсдэлийн удирдлагын хорооны нарийн бичиг /Д.Дэлгэрмаа/-д тус тус үүрэг болгов.

ХЯНАСАН:

Эрсдэлийн удирдлагын хорооны дарга:

 М.Эрдэнэсайхан

БОЛОВСРУУЛСАН:

Эрсдэлийн удирдлагын хорооны нарийн бичиг:

 Д.Дэлгэрмаа